



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А-164

Улаанбаатар хот


Гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан хэрэгцээнд сервер, сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэл, 05 дугаар сарын 19-ний өдрийн 21/003059 бүртгэлийн дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сервер, сүлжээний тоног төхөөрөмжийг 152,072,140.0 /Нэг зуун тавин хоёр сая далан хоёр мянга нэг зуун дөч/ төгрөгөөр нийлүүлэхээр "Саммит компьютер технологи" ХХК-ийн ирүүлсэн тендерийг шаардлагад нийцсэн "Хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосугай.

2. "Саммит компьютер технологи" ХХК-тай гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа тендер хүчинтэй байх хугацаанд багтаан хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Ц.Болорчулуун/-т даалгасугай.

ДАРГА



Т.ЖАМБАЛЦЭРЭН

00000631